

# Хүнд цаг үед тэсвэр хатуужлыг бэхжүүлэх нь

2020 онд дэлхийн өнцөг булан бүрт эмэгтэйчүүд асар их саад бэрхшээлтэй тулгарч, олон нийтийнхээ болон дэлхий ертөнцийн амь амьдралыг авч гарахын төлөө олон нийтийг тэсвэр хатуужилтай болгох бүтэц тогтолцоог бэхжүүллээ. GAGGA болон түнш байгууллагуудын хувьд КОВИД-19 цар тахал нь урьд хожид тохиолдож байгаагүй хүнд нөхцөл үүсгэснээр бид үйл ажиллагааны чиглэл, төлөвлөгөөгөө эргэн харж, өөрчлөх шаардлагатай болсон. GAGGA-гийн түншүүд маш олон саад тогторыг даван туулахын зэрэгцээ хоорондоо харилцах, холбоо барьж, эв нэгдлээ илэрхийлэх, зохион байгуулах ажлаа үргэлжлүүлэх чиглэлээр шинэлэг аргуудыг боловсруулж ажилласан.



Төрөл зураг: Sabokahan Unity of Lumad Women

## GAGGA 2020 онд: Онцлох тоо баримт

426

эмэгтэйчүүдээр удирдуулсан, олон нийтэд түшиглэсэн байгууллагыг GAGGA дэмжсэн

79%

нь нийт 2.2 сая Евроны тэтгэлэг хүртсэн

21%

нь зөвхөн санхүүгийн бус дэмжлэг авсан

## Цахим орчинд үйл ажиллагаа зохион байгуулсан нь

Эмэгтэйчүүдээр удирдуулсан анхан шатны бүлгүүд цахим орчинд үйл ажиллагаанд оролцож, дижитал арга хэрэгслийг аюулгүй бөгөөд үр дүнтэй байдлаар ашиглахад GAGGA-гийн түншүүд тусалж ажилласан. Байгууллагууд гар утсанд нь дата багц худалдаж авч өгөх, интернэтэд холбогдсон хамгийн ойр хот, тосгон руу аюулгүй байдлыг нь хангаж зорчуулах, компьютер дээр ажиллах ур чадварыг нь дээшлүүлэх, үндэсний ба олон улсын виртуал орон зайд үйл ажиллагаанд хэрхэн оролцох талаар сургалт явуулах зэрэг стратегиуд ашигласан.

*Аналог ойн аж ахуйн олон улсын сүлжээ* байгууллага нь Боливи, Коста-Рика болон Эль Сальвадор улсад *Аналог ойн аж ахуйг түгээн дэлгэрүүлэгч эмэгтэйчүүдэд зориулсан цахим орон зайг* бий болгосон. УотсАпп, Сигнал зэрэг мессэжийн аппликейшнээр дамжуулан түгээсэн аудио мессэж, дүрс бичлэгийн ачаар тэд Аналог ойн аж ахуйн мэргэжлийн нөү-хау, эмэгтэйчүүд нөхөн төлжилтийн талбайн загвар, дизайныг хэрхэн боловсруулж, хэрэгжүүлсэн тухай болон хөдөө орон нутгийн олон нийт, тэр дундаа эмэгтэйчүүдэд хүрч очиж ажиллах аргачлалын талаар мэдээллээ хуваалцсан. Энэ дижитал орон зай нь тус аж ахуйг түгээн дэлгэрүүлэгч эмэгтэйчүүдийн дунд итгэлцлийн тойрог үүсгэж, харилцан бие биенээ дэмжихэд нөлөөлжээ. **Залуу феминистүүдийн сан буюу ФРИДА** нь *цахим орчин дахь халамж ба аюулгүй байдлын талаар цуврал контент* боловсруулж, интернэтийн үндсэн дэд бүтэц, аюулгүй мессэжийн аппликейшн, тоног төхөөрөмж ашиглах үеийн цахим орчин дахь халамж зэрэг сэдвүүдийг хөндсөн. Ингэхдээ уур амьсгал, байгаль орчныг хамгаалагч залуу феминистүүдэд онцгой анхаарал хандуулжээ.

GAGGA нь хамтын мэдлэг хуримтлуулах, эргэцүүлэн тунгаах арга хэмжээг цахим орчинд зохион байгуулсан нь манай хөндлөнгийн үнэлгээний үйл явцад хувь нэмэр оруулаад зогсохгүй цаашид хэрэгжүүлэх санаа өгсөн. Эдгээр хэлэлцүүлэг нь **GAGGA-гийн 'Уур амьсгалын үйл ажиллагаанд эмэгтэйчүүд манлайлах нь' хөтөлбөр** (дор харна уу), *уур амьсгалын шударга ёсны асуудлаар эмэгтэйчүүдийн манлайллыг хөнддөг мэдээллийн товхимол* боловсруулахад тус дөхөм үзүүлжээ. Байгаль орчин, хөгжлийн төлөөх эмэгтэйчүүдийн байгууллага болон “Эх дэлхийн найзууд” олон улсын байгууллагатай хамтран GAGGA нь Талуудын 26 дугаар Бага Хурлын Эвслээс зохион байгуулсан ‘Анхан шатнаас өгсөх нь’ дэлхийн чуулга уулзалтын үеэр салбар хурал зохион байгуулжээ. **‘Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг феминист үйл ажиллагаа: Бүх түвшинд эрх мэдлийг бэхжүүлэх нь’** сэдэвт тус хуралд 150 гаруй хүн оролцов.

2016 онд байгуулагдсан Жендэр ба ногоон үйл ажиллагааны дэлхийн эвсэл (GAGGA) нь дэлхий дахинаа эмэгтэйчүүдийн эрх, байгаль орчны болон уур амьсгалын шударга ёсны төлөөх хөдөлгөөнүүдийн хамтын хүчийг нэгтгэдэг. GAGGA-гийн алсын хараа нь ус ба хүнсний аюулгүй байдлаар хангагдах, цэвэр, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эмэгтэйчүүдийн эрхийг хүлээн зөвшөөрч, эрхэмлэдэг дэлхийг бий болгоход оршино. Энэ ажлыг *Төв Америкийн эмэгтэйчүүдийн сан (FCAM)* нь *Мама Каш*, *Both ENDS* байгууллагуудтай хамтран хийж гүйцэтгэдэг. Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл, *манай цахим хуудсаар* зочилж, *Твиттер* дээр биднийг дагаж, *манай мэдээллийн товхимлыг захиалж уншаарай*.

## Орон нутгийн ба үндэсний түвшинд эмэгтэйчүүдийн эрх болон байгаль орчны шударга ёсыг эрхэмлэн дээдлэхийг баталгаажуулах нь

GAGGA-гийн түншүүд амжиргаа, хүнсний аюулгүй байдал болон цэвэр, аюулгүй усны хүртээмжийг баталгаажуулахын хажуугаар газар нутаг, нутаг дэвсгэрээ эрх мэдэлдээ байлгах буюу эргүүлэн авахын тулд тогтвортой бөгөөд олон нийтэд түшиглэсэн дадал практикаа үргэлжлүүлэн бэхжүүлсэн. GAGGA-гаас дэмжсэн анхан шатны бүлгүүдийн нөлөөлөл, лобби ажлын санаачлагууд нөхөн сэргээлт / экологи хамгаалалт (биологийн төрөл зүйлийг оролцуулаад); даацтай хөдөө аж ахуй; уур амьсгалын өөрчлөлт; эрхмэдэлжилт ба эдийн засгийн хараат бус байдал зэрэг асуудлуудад төвлөрсөн.

Индонез улсад газрын гүний дулаан, усан цахилгаан станц болон салхин тээрийн төслүүд боловсруулах ажил, төлөвлөгөөний явцад нөлөөнд нь өртөх орон нутгийн олон нийттэй нэг ч удаа зөвшилцөж ярилцаагүй байна. 2020 онд GAGGA-гийн түнш **Акси! Феминист оролцооны үйл ажиллагааны судалгаа хийж, сэргээгдэх эрчим хүчний төслүүдийн сөрөг нөлөөний талаар** 50 гаруй эмэгтэйгээс ярилцлага авч эмхэтгэжээ. Энэ судалгаа нь Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн (ЭЯГБХУТК) Хороонд Акси!-гаас “Сламет уулаа аваръя” байгууллагатай хамтран илгээсэн тайлангийн үндэс суурь болсон ба тайлангийн үр дүнд Индонезийн Засгийн Газар цаашид ямар арга хэмжээ авахыг шууд хянахад хүргэжээ. Дугуй ширээний ярилцлага хийж, “Эрчим хүчний төсөл хэрэгжиж буй газар амьдардаг эмэгтэйчүүд ярьж байна” нэртэй вебинар зохион байгуулснаар Акси! нь эмэгтэйчүүд болон орон нутгийн олон нийтийн үзэл бодол, зөвшөөрөл болон хяналтад үндэслэн ардчилсан бөгөөд оролцоог хангасан байдлаар боловсруулсан **хүн төвтэй шийдэл, хувилбарууд** шаардлагатай байгааг онцлов.

Нигерийн Порт-Харкорт-д төвтэй **Kebetkache Эмэгтэйчүүдийн хөгжил, мэдээллийн төв, Lokiaka олон нийтийн хөгжлийн төв** нь Нигерийн Дельта мужийн эмэгтэйчүүд, орон нутгийн олон нийтийн өмнө тулгамдаж буй газрын тос олборлох, хий шатаахтай (газрын тосны компаниуд өрөмдлөгөөс алдагдах хийг шатаадаг) холбоотой асуудлын талаарх ойлголтыг дээшлүүлжээ. 2019 оны GAGGA-гийн “Холбоотой байж, харилцан суралцъя” тэтгэлэг нь дээрх 2 байгууллагын хамтын ажиллагаанд түлхэц болсон бол, 2020 онд Kebetkache нь Лолоума болон Умуэчем олон нийтийн эмэгтэйчүүдийн **хий шатаахын эсрэг “Үгүй” гэж хэлэх эрх** болон шийдвэр гаргагчдыг тодорхойлж, хэрхэн хамтран ажиллах чадавхийг бэхжүүлсэн. Мөн олон нийтийн гишүүд, иргэний нийгмийн байгууллагууд, Гадаад хэргийн яам, Байгаль орчны яам болон Үндэсний чиг баримжаа олгох агентлагийн төлөөлөл бүхий чуулганыг зохион байгуулав. Чуулганаар Риверс мужийн Эмэгтэйчүүдийн асуудал хариуцсан яам дэвшүүлсэн асуудал, ялангуяа хий шатаах болон холбогдох бохирдлын эмэгтэйчүүдэд үзүүлэх үр нөлөөнд анхаарал хандуулахаар амлалт авчээ.

## Олон улсын санхүүгийн байгууллагуудад шахалт үзүүлсэн нь

КОВИД-19-ын улмаас үүссэн саад бэрхшээлийг үл харгалзан GAGGA нь Олон улсын санхүүгийн байгууллагуудын нийгмийн ба байгаль орчны бодлого боловсруулах, сайжруулах болон хяналт үнэлгээний ажилд үргэлжлүүлэн оролцож, нөлөөлж, хувь нэмрээ оруулсан. GAGGA-гийн түнш байгууллага, гишүүд нь Африкийн хөгжлийн банк, Азийн хөгжлийн банк, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк, Европын сэргээн босголт хөгжлийн банк болон Америк хоорондын хөгжлийн банктай хамтран ажиллав. **Банкууд нийгмийн болон байгаль орчны бодлогоо дагаж мөрдөхтэй холбоотойгоор төслийн санал, хэрэгжилтийг нэн даруй үнэлэх** шаардлагатай байгаад тэд анхаарлаа төвлөрүүлсэн.

Гватемал дахь 2 томоохон усан цахилгаан станцын төсөл болох Пожом II болон Сан Андрес нь банкны Жөндөрийн эрх тэгш байдлын тухай Үйл ажиллагааны бодлого зэрэг олон бодлогыг зөрчсөн учраас **Байгаль орчныг хамгаалах Америк хоорондын холбоо (AIDA)** нь зохих арга хэмжээ авахыг шаардан **Америк хоорондын хөгжлийн банканд (АХХБ)** шахалт үзүүлсээр иржээ. Цар тахлын улмаас AIDA нь АХХБ-тай холбоотой албан ёсны орон зайд шууд нэвтэрч, оролцож чадаагүй ч, тус бүлэг нь олон нийтийн ойлголтыг дээшлүүлж, нөхцөл байдлыг шүүмжилж, ялангуяа эдгээр төслийн улмаас эрх нь зөрчигдсөөр ирсэн орон нутгийн **Ixquisis эмэгтэйчүүд** болон холбогдох олон нийттэй холбоотой байж, **эв санааны нэгдлээ илэрхийлсээр** иржээ. AIDA олон янзын цахим арга хэмжээ зохион байгуулж, онлайн өргөдөл гаргах болон харилцаа холбооны кампанит ажлууд явуулснаар төслүүдийн хор уршгийг бүсийн хэмжээнд олон нийтэд таниулж, Ixquisis олон нийтэд үзүүлэх дэмжлэгийг эрчимжүүлсэн байна.



Гэрэл зураг: Women African Alliance



## Уур амьсгалын ногоон сантай хамтран ажилласан нь

GAGGA-гийн түнш байгууллагууд **Уур Амьсгалын ногоон сангийн (УАНС) шийдвэр гаргах** үндэсний үйл явцад оролцох чиглэлээр олон нийтийн ойлголтыг дээшлүүлж, анхан шатны бүлгүүдийг дайчлах зорилгоор мэдлэг дээшлүүлж, чадавхи бэхжүүлэх сургалтууд хийсээр ирсэн. GAGGA Индонез, Монгол, Непал болон Танзани улс дахь эмэгтэйчүүдийн эрхийн байгууллагуудыг **өөрийн улсын УАНС-гийн Үндэсний эрх бүхий байгууллагатай бодлогын асуудлаар хэлэлцэхэд** идэвхтэй оролцуулж, шийдвэр гаргах үндэсний үйл явцад оролцох оролцоог нь дээшлүүлэхэд дэмжсэнээр төслийн хэрэгжилтэд жендэрийн шинжээчээр хангаж, засгийн газар / эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах албан ёсны арга замыг ашиглаж, тухайн улс дахь өнөөгийн болон цаашид хэрэгжүүлэх УАНС-гийн төсөлд мониторинг хийв.

Түүнчлэн бусад оролцогч талуудын хамтаар GAGGA түншүүдийн хэрэгцээ шаардлагыг УАНС-гийн шийдвэр гаргах олон улсын үйл явцад төвлөрүүлж, орон нутгийн оролцоо, жендэрийн мэдрэмжтэй хариу үйлдэл болон оролцоог хангасан шийдвэр гаргах үйл явцыг хөхиүлэн дэмжсээр ирсэн. 2020 оны удирдах зөвлөлийн хурлын үеэр бид санхүүжилт хүссэн төсөл, саналуудын **жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө болон жендэрийн үнэлгээг сайжруулах** чиглэлээр нөлөөлж ажиллахын зэрэгцээ, эдгээр орон зайд төрөл бүрийн бүс нутаг, олон нийтийн шууд оролцоо, төлөөлөл байх ёстойг хангасан. Тухайлбал, УАНС-гийн Азийн бүсийн жендэрийн шинжээч бөгөөд **Тайландын Уур амьсгалын хяналт** байгууллагын Ванун Пермпбул нь УАНС-гийн удирдах зөвлөлийн хуралд оролцож, ИНБ-уудын Идэвхтэй ажиглагч багийн гишүүнээр сонгогдсон. Түүнчлэн GAGGA-г оролцуулсан ИНБ-уудын томоохон бүлгийн хамтын нөлөөлөл нь нүүрсний үйлдвэр хөгжүүлэгчдэд олгодог дэлхийн 3-дагч том зээлдүүлэгч болох “Сүмитомо Мицүи” банк санхүүгийн корпорацийн (СМБСК) үйл ажиллагааг УАНС-гийн хөтөлбөрөөс түдгэлзүүлж, УАНС ба Парисын Гэрээний зорилго, зорилтуудтай нийцээгүй хэрэглээний болон эрчим хүчний хөрөнгө оруулалтын бодлогоо сайжруулахыг СМБСК-иас шаардахад хүргэсэн.

## Нөөц бүрдүүлэлтийг сайжруулсан сайн туршлага

Стратегийн түншүүд болох Дэлхийн Ногоон Тэтгэлэг Сан болон Проспера-Олон улсын эмэгтэйчүүдийн сангийн сүлжээтэй хамтран GAGGA нь байгаль орчны болон уур амьсгалын үйл ажиллагааг манлайлан ажиллаж буй орон нутгийн эмэгтэйчүүдээр удирдуулсан хөдөлгөөнүүдэд зориулж оролцоог хангасан, уян хатан, феминист бөгөөд олон нийтэд түшиглэсэн нөөц бүрдүүлэлттэй болохын төлөө **хандивлагч засгийн газрууд болон филантропи олон нийтийн эрч хүч**, ашиг сонирхолыг бэхжүүлэхээр ажилласан. GAGGA-г өөрсдийн ажил, ажлын үр дүнгээ танилцуулаач хэмээн Канад улсын Гадаад хэргийн яам болон яамны Уур амьсгалын санхүүжилт, Хүнсний систем болон Байгаль орчны хэлтсүүд урихын сацуу, Нэгдсэн Вант Улсын Гадаад хэрэг, хамтын нөхөрлөл, хөгжлийн яам уулзах хүсэлт ирүүлсэн билээ.

Дэлхийн Ногоон Тэтгэлэг Сан болон Проспера нь хувийн сангуудаас бүрдсэн бүлэг болох **Эмэгтэйчүүд, байгаль орчны төлөөх санхүүжүүлэгчдийн сургалтын нийгэмлэгтэй** (FLC) үргэлжлүүлэн хамтран ажилласан. FLC-ийн үнэлгээнд оролцогчдын 82 хувь нь уур амьсгалын өөрчлөлт болон байгаль орчны бусад гарз хохиролтой тэмцэх чухал санаачлагуудыг эмэгтэйчүүд хэрхэн манлайлан ажиллаж буй талаар суралцахын зэрэгцээ сүүлийн 2 жилийн хугацаанд суралцсан ихэнх сэдвийн хүрээнд тэдний мэдлэг “их хэмжээгээр” өөрчлөгдсөн буюу дээшилсэн гэж хариулжээ.

GAGGA-гийн түнш байгууллага, гишүүд доноруудад амжилттай нөлөөлснөөр 2020 онд байгаль орны болон уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг эмэгтэйчүүдээр удирдуулсан, жендэрийн мэдрэмжтэй ажлуудад дэмжлэг үзүүлж чадсан.

- 2020 онд **GAGGA-гийн түншүүдийн 53 хувь нь шинэ донороос санхүүжилт авсан гэж мэдээлсэн** нь наад зах нь 1.9 сая Евро<sup>1</sup> болжээ. Хэдийгээр шинэ доноруудын тоо өссөн нь эерэг мэдээ боловч, санхүүжилтийн нийт дүн нь өмнөх жилүүдтэй харьцуулахад доогуур байгааг энд онцлох нь чухал.
- 2021-2025 оны “Дуу Хоолойн Хүч” бодлогын хүрээнд **Голланд улсын Гадаад хэргийн яам GAGGA-г Стратегийн Түншээр сонгосон**. Ингэснээр GAGGA-гийн ‘Уур амьсгалын үйл ажиллагааг манлайлж буй эмэгтэйчүүд’ хөтөлбөр нь 34 сая Евроны тэтгэлэг авсан.
- Форд сан нь шинэ Тэсвэртэй эмэгтэйчүүд болон байгалийн баялаг плюс сангийн хүрээнд эмэгтэйчүүдийн эрх, байгаль орчны болон уур амьсгалын шударга ёсны чиглэлээр дэлхийн өмнөд зүгийн улс орнуудад ажиллаж буй **олон нийтэд түшиглэсэн, эмэгтэйчүүд удирддаг бүлэг, хоршоо болон байгууллагуудын зураглалыг** хийлгэхээр GAGGA-д 100,000 ам долларын тэтгэлэг олгосон. Тус зураглал нь **байгаль орчин, газар нутаг болон нутаг дэвсгэрээ хамгаалагч охид, эмэгтэйчүүдийн өмнө тулгамддаг бүтцийн хүчирхийллийн** төрөл, хэлбэр болон тэд хэрхэн хариу үйлдэл үзүүлж буйг судалсан.

<sup>1</sup> Үүнд GAGGA-гийн эвслийн гишүүд болох FCAM, Both ENDS ба Мама Кашийн авсан шинэ санхүүжилтийг оруулаагүй.

## Хөдөлгөөн хоорондын хамтын ажиллагаа болон эвсэл байгуулах үйл явц

КОВИД-19-ын хямралын хүрээнд GAGGA-гийн хөдөлгөөн хоорондын өвөрмөц хамтын ажиллагааны давуу тал нь олон янзаар илэрсэн. Дэмжлэг үзүүлсэн орон нутгийн хөдөлгөөнүүдийн бодит байдал, хэрэгцээг бид нэн даруй ойлгож, ажлын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах шаардлагатайг олж харсан. 5-р сард GAGGA нь нэг удаагийн санхүүжилтийн санаачлага болох **Хараат бус, тэсвэртэй байдлын санг** (ARF) эхлүүлсэн бөгөөд тус сангийн зорилго нь тэгш байдал, эв санааны нэгдэл болон хүн, байгалийн төлөө хамтын халамж үзүүлэх зарчмуудад суурилсан **тэсвэртэй ба хараат бус байдлын олон нийтэд түшиглэсэн тогтолцоог** бэхжүүлснээр байгаль орчныг хамгаалагч эмэгтэйчүүд болон тэдгээрийн олон нийтийн нэн яаралтай хэрэгцээг хангах явдал байв. GAGGA-гийн сүлжээний бүтэц, тэр дундаа сүлжээний харилцаа, итгэлцэл нь Сангийн амжилтын гол түлхүүр байсан. Дөнгөж 6 долоо хоногийн дотор GAGGA нь олон нийтэд түшиглэсэн эмэгтэйчүүдийн 193 байгууллага, GAGGA-гийн түнш 18 ТББ-аас нийт 211 өргөдөл хүлээж авсан. 3 сарын хугацаанд GAGGA **дэлхийн 21 улсын 41 анхан шатны бүлэгт €214,108, 7 ТББ-д €40,292-ийн тэтгэлэг олгов.**

Тэтгэлэг олгох үйл явц эцэслэсний дараа GAGGA нь хямралын цаг үед байгаль орчныг хамгаалагч эмэгтэйчүүд, тэдний эргэн тойрны олон нийтийн туршлага, үзэл бодол болон хэрэгцээг ойлгож, мэдэж авах зорилгоор Хараат бус, тэсвэртэй байдлын сангийн судалгааг захиалан хийлгэсэн. [Хараат бус, тэсвэртэй байдлын сан: Айдсыг найдвар болгон хувьсган өөрчлөх нь](#) нэртэй тайлан нь урт, богино хугацаанд жендэрийн, байгаль орчны болон уур амьсгалын шударга ёсны төлөө оролцоог хангасан, уян хатан, феминист, олон нийтэд түшиглэсэн нөөц бүрдүүлэлтийн тухай чухал хэлэлцүүлэгт хувь нэмэр оруулсан.

## GAGGA-гийн сүлжээ байгууллагуудын дуу хоолой

3-р сарын 8-22-нд буюу Олон улсын эмэгтэйчүүдийн өдрөөс Дэлхийн усны өдөр хүртэл Латин Америк дахь GAGGA-гийн түнш байгууллагууд жил бүрийн ['Эмэгтэйчүүд бид бол ус' аяны ажлыг](#) 4 дэх удаагаа зохион байгуулсан. Тус кампанит ажил нь усыг хайрлан хамгаалахад Латин Америкын эмэгтэйчүүдийн үүрэг роль болон манлайллыг онцлохын зэрэгцээ энэхүү нийтийн өмчийг шавхаж, бохирдуулснаар эмэгтэйчүүдэд ямар үр нөлөө авчирч буйг тод томруун харуулсан. Аяны ажил эхлэх үе нь КОВИД-19-ын халдвар ноцтой болох нь тодорхой болсон үетэй давхцсан учраас, аяны ажлын гол мессэж нь гар угаах зэрэг энгийн үйлдлээс авахуулаад [КОВИД-19 цартахлын үед усаар хангагдах хүний эрхийг](#) хангахын чухал ач холбогдол байсан юм.

Түүнчлэн GAGGA нь КОВИД-19-ын нөхцөл байдалд орон нутгийн эмэгтэйчүүд болон тэдгээрийн олон нийтийн тухай ойлголтыг дээшлүүлж, бодит байдлыг ил болгосон. GAGGA нь цартахлын эхний саруудын туршлагаасаа хуваалцсан Ази, Африк, Латин Америк дахь түншүүдээс 60 гаруй бичлэгийг цуглуулсан. [Аудио түүхүүдийг](#) Твиттерээр цацсанаар хүмүүс түүнийг 17,500 удаа үзэж, Твиттер хэрэглэгчид 600-аас дээш удаа ашиглахын хажуугаар хөндлөнгийн мэдээллийн сувгууд энэ талаар мэдээлжээ.

## Голландын Гадаад хэргийн яамтай хамтран ажилласан нь

2020 онд Голландын Гадаад хэргийн яамтай хамтран ажилласан GAGGA-гийн ажлын онцлох үйл явдал нь **Эмэгтэйчүүд, оролцоо болон байгаль орчны чиглэлээр дугуй ширээний ярилцлага** хамтран зохион байгуулснаар байгаль орчин болон уур амьсгалын бодлого боловсруулдаг Канад, Голланд, Герман, Швейцарь болон Нэгдсэн Вант Улсын засгийн газрууд болон АНУ, Европын хувийн сангуудын нийт 40 гаруй төлөөлөгчдийг нэг дор хуран цугларуулжээ. Энэхүү ярилцлагыг тус Яамны Оролцоонд тулгуурласан ногоон хөгжлийн газартай хамтран зохион байгуулж, 5 хандивлагч засгийн газрын холбогдох бодлого, механизм, арга хэрэгсэл болон санхүүжилтийн сувгуудын талаар 2019 онд боловсруулсан [зураглалын](#) үр дүнд түшиглэж, ярилцлагын оролцогчид мэдлэг, туршлагаа солилцох боломжтой болсон. Түүнчлэн хүчин төгөлдөр хэрэгжиж буй санхүүжилтийн механизмаар дамжуулан **орон нутгийн иргэд, олон нийт**, тэр дундаа эмэгтэйчүүд, уугууль иргэд, хөдөө орон нутгийн болон далайн эрэг хавийн тариаланчид, загасчид зэрэг эрхээ хасуулсан бүлгүүдэд **Яамны хямралын үеийн санхүүжилт нь хүртээмжтэй байхыг хангахын** төлөө GAGGA нөлөөлсөн.

## GAGGA-гийн сүүлийн 5 жилийн сургамж

2016 оноос хойш GAGGA эмэгтэйчүүдийн болон байгаль орчны шударга ёсны сангаар дамжуулан **эмэгтэйчүүдийн эрх, байгаль орчны шударга ёс чиглэлээр ажилладаг анхан шатны бүлгүүдэд зориулж нийт €10.24 сая бүхий 1,518 тэтгэлэг олгосон.** Эхний 5 жилийн хөтөлбөрийн эцсийн хөндлөнгийн үнэлгээгээр бид 5 жилийн зорилтдоо хүрэхэд чухал ахиц дэвшил гаргасан хэмээн дүгнэжээ.

Сүүлийн 5 жилд хуримтлуулсан бидний туршлага **эмэгтэйчүүдийн эрхийн, байгаль орчны болон уур амьсгалын шударга ёсны төлөөх хөдөлгөөнүүдийг нэгтгэж, эмэгтэйчүүдээр удирдуулсан, олон нийтэд түшиглэсэн байгууллагуудын мэдлэг, туршлагыг байгаль орчны болон уур амьсгалын үйл ажиллагаа, байгаль орчин, уур амьсгалтай холбоотой бодлогод төвлөрүүлэхийн** чухал ач холбогдлыг бидэнд тов тодорхой болгосон.

Бүхий л олон янзат байдлын төлөөлөл болсон эмэгтэйчүүд одоо цагт тулгарч буй болон ирээдүйд тулгамдах байгаль орчны доройтол, уур амьсгалын сөрөг үр нөлөөг хөндөөд зогсохгүй тэдний болон тэдгээрийн эргэн тойрны олон нийтийн бодит байдлыг эерэг байдлаар хувьсган өөрчлөхийн тулд зоригтой, бүтээлч, цогц шийдлүүдийг авч хэрэгжүүлж байна. GAGGA-гийн эхний 5 жилийн үйл ажиллагааг дүгнэж буй энэ цаг үед бид хамтын хүчээр хүрсэн ололт амжилтаараа бахархахын хажуугаар сүлжээ нь цаашид хэр өргөжин тэлэхийг харахыг тэсэн ядан хүлээж байна.

